


БАТЛАВ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Х.ЭНХЦЭЦЭГ



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Барилга угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийх фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэнэ.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. Барилгын норм ба дүрмийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Уртын голын ногоон байгууламжийн ажил:

Гүйцэтгэгч: Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2 дугаар багийн баруун хэсэгт орших Уртын голыг сэргээн, эргийн дагуу тохижилт хийн хотын иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, соёл боловсролыг дээшлүүлэх, эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг ихэсгэх зорилгын хүрээнд нийт 166 га талбайн 0.5 га талбайд овоо, 1.2 га талбайд гадна талбай, 1.4 га талбайд явган зам, 0.8 га талбайд гүйлтийн зам, 0.1 га талбайд 180 авто машины зогсоол, үлдсэн талбайд ногоон байгууламж буюу мод тарихаар төлөвлөсөн. Уг байгууламжийн 0.55 га талбайд үйлчилгээний 3,6x3.6 метрийн харьцаатай 7 ширхэг түргэн үйлчилгээний цэг, 3.6x3.6 харьцаатай 2 ширхэг харуулын байрыг тусгасан. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл (Зураг төслийн шифр: ХТХ-16/2022), мөн стандарт, технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Гадна зам талбай: Гадна зам талбайг зурагт тусгасны дагуу өнгө хэмжээгээр хийнэ. Зам талбайн хавтан нь халтирхааргүй барзгар гадаргуутай байна. MNS6808:2019 стандартыг мөрдөн ажиллана.

Ногоон байгууламж: Мод сөөг, ургамлыг тарихдаа тухайн орчин байгаль цаг уурын онцлогт тохирсон, ус чийг хөрсний шингээлт сайн, ургамал газарзүйн мужлал цөлжилтийг саармагжуулах чадвар сайтай зураг тусгагдсан 8 төрөл зүйлийн 150.0 мянга ширхэг мод тарьж бордох ба мод хоорондын зай 2-3м байна.

Ногоон байгууламж тарих MNS 62-58-1:2011, 62-58-2:2011, 5973:2019 стандартыг барьж ажиллах.

Услалтын систем: Иж бүрэн багц дуслын усалгааны системтэй байх ба 150 га талбайд 150.0 мянган ширхэг модны усалгаанд хүрэлцэхүйц хүчин чадал бүхий систем байна. Тус дуслын усалгааны системээр мод нэг бүрийг услаж, бойжуулах зориулалттай байна.

Гүний худаг: 7-н ширхэг гүний худгийн усны хайгуул судалгааг хийж, худгийн цооног өрөмдөх, тоноглох, худгийн байшин барих ажлыг хийж гүйцэтгэхээс гадна худаг тус бүр цахилгааны монтаж, насос, паспоржуулалттай байна.

Усны нөөц сав: 50 тонн 7 ширхэг нөөцийн савтай, тухайн усалгааны системд тохирсон хүчин чадал бүхий 7 ширхэг помптой байна.

Гүүр: Төлөвлөлтийн талбайд 2 гүүр төлөвлөсөн ба 1 гүүр нь 40м урттай явган болон гүйлтийн зам нь театрлуу холбосон, 1 гүүр нь тойрог бүхий 20м радиустай голруугаа чиглэсэн байна.

Тавцан: Төлөвлөлтийн дунд хэсэгт 15x46м харьцаатай мөн голруугаа харсан 10190м² өнгөт хавтан, 3200м² чулуун хучилт 950м хашлагатай гүүрэн тавцан байна.

Сүүдрэвч: Төлөвлөлтийн дунд хэсэгт 18x5м харьцаатай, металл рам хийцтэй, цутгамал бетон шаталсан сандалтай сүүдрэвч байна.

Түргэн үйлчилгээний цэг: Тэнхлэгээрээ 3.66x3.66м харьцаатай бөгөөд үндсэн хийц нь модон давхар рамтай, шилэн хөвөн дулаалгатай шахмал хавтан хашлагатай байна.

Харуулын байр: Тэнхлэгээрээ 3.66x3.66м харьцаатай төмөр суурьтай 2 давхар бөгөөд үндсэн хийц нь модон давхар рамтай, шилэн хөвөн дулаалгатай шахмал хавтан хашлагатай байна.

Овооны ажил : 5943.4м² явган замын өнгөт хавтан, 3200м² боржин чулуун өнгөлгөөний ажил, 8910.4м³ шороо зөөж 30563.5м² талбай тэгшлэх.

Дугуй болон гүйлтийн зам: 8385.5м² асфальт, 14203.4м² явган замын өнгөт хавтан хучилт, 11228 метр замын хашлага тавих.

Дугуй явган гүүр: 132м³ төмөр бетон хийц, 50.7 тонн төмөр хийцтэй.

Явган гүүр: 115.6м³ төмөр бетон, 19.24тн төмөр хийц, 202 м² WPS өнгөлгөөтэй тавцан, 1250м² хашлага тор, 306м³ хайрган манаас хийж өгөх.

Тоглоомын талбай: 830.4м² өнгөт хавтан, 304.6м² чулуун хучилт, элсэн дэвсгэртэй волейболын талбай 3 ш тоноглолтой байна.

Тохижилт: 52 сандал, 76 хогийн сав, 5 хог түр хадгалах сав, 13 ширхэг модон саравчтай байна.

Сүүдрэвч: 2 ширхэг сүүдрэвч 3.4 тонн металл каркас, 562м² мембран материал бүрхүүлтэй, 40м³ бетон суудлыг 36м² банзаар өнгөлсөн хийцтэй байна.

Цахилгаан иж бүрдэл: КТПН-160 кВт, өндрийн кабель, нам талын кабель, талбайн гэрэлтүүлэг зэргээс бүрдэнэ.

Барилга угсралтын ажлыг 2022 онд барилгын зураг төслийн "Хот төлөвлөлтийн хүрээлэн" ХХК-д боловсруулагдсан 2022 оны 09 дүгээр сарын 29-

ны өдрийн 1827/2022 магадлалын дүгнэлттэй барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Угсралтын ажлын явцад Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-04-06, БНБД 12-03-04 мөрдөх шаардлагатай ба угсралтын ажлын зурагт заасан технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилга байгууламжийн ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэгт өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Магадлашгүй ажлын зардлыг хэрхэн ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага /тусгай гэрээгээр/ болон хяналтын инженер танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу аймгийн ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Инженер геологи, зураг төслийн зардал болох 125,400,000 /нэг зуун хорин таван сая дөрвөн зуун мянга/ төгрөг болон бусад зардлыг тооцож ирүүлнэ.

Дээрхи техникийн тодорхойлтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөл, барилгын хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

З.Мөнхбаяр

